

# САНГИЙН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

(2023 оны 8 дугаар сар)

Яамны газруудын 2023 оны 8 дугаар сарын үйл ажиллагааны биелэлтийг “Яамны дотоод бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-д заасан дараах 5 шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд үнэлгээний дундаж 98.2 хувьтай байлаа.



**99.3%**  
Сарын  
төлөвлөгөө  
24.8 оноо



**97.0%**  
Албан бичгийн  
шийдвэрлэлт  
9.7 оноо



**100.0%**  
Шуурхай үүрэг  
даалгавар  
5.0 оноо




**94.1%**  
Ажлын цаг  
ашиглалт  
9.4 оноо



**100.0%**  
Үйл ажиллагааны  
ил тод нээлттэй байдал  
10.0 оноо

## Газруудын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ /2023.08/

№	Газар	Сарын төлөвлөгөө	Албан бичгийн шийдвэрлэлт	Ш/ү даалгаврын хэрэгжилт	Цаг ашиглалт	Ү/а-ны ил тод нээлттэй байдал	Нийт		Хувь
		Авсан оноо	Авсан оноо	Авсан оноо	Авсан оноо	Авсан оноо	Нийт авах	Авсан оноо	
1	ТБТГ	25.0	9.5	5	9.5	10.0	60.0	59.0	98.3
2	ТаБГ	25.0	9.4	5	9.6	10.0	60.0	59.0	98.3
3	НБББГ	25.0	10.0	-	8.1	10.0	55.0	53.1	96.5
4	СБГ	24.0	9.5	5	9.7	10.0	60.0	58.2	97.0
5	ХСХОГ	24.7	9.9	5	9.2	10.0	60.0	58.8	98.0
6	СТСГ	25.0	9.2	5	10.0	10.0	60.0	59.2	98.7
7	ТЗУГ	24.5	9.6	5	9.3	10.0	60.0	58.4	97.3
8	ТСГ	25.0	10.0	-	9.1	10.0	55.0	54.1	98.4
9	СХЭУГ	25.0	10.0	5	10.0	10.0	60.0	60.0	100.0
10	ХЭЗГ	25.0	9.8	-	9.7	10.0	55.0	54.5	99.1
Нийт дундаж							585	574.3	98.2



Сангийн яамны Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн А/116 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Яамны дотоод бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх, үр дүнг үнэлэх журам”-ын дагуу яамны газруудын 2023 оны 8 дугаар сарын үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ үнэлгээ, хийж, үр дүнг үнэлэхэд дунджаар **98.2 хувьтай** байлаа.

2023 оны 8 сарын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээгээр СХЭУГ 100.0, ХЭЗГ 99.1, СТСГ 98.7 хувиар тэргүүлж байна.

*/Дэлгэрэнгүйг хавсралт 1-ээс үзнэ үү/*



## Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт (8 сар)

**99.3**  
хувь

№	Газар	Нийт арга хэмжээ	Хэрэгжилт							Үнэлэх боломжгүй	Биелэлтийн хувь	Авсан оноо
			100	90	70	50	30	0				
1	ТБТГ	10	10	-	-	-	-	-	-	100.0%	25.0	
2	ТаБГ	6	6	-	-	-	-	-	-	100.0%	25.0	
3	НБББГ	6	6	-	-	-	-	-	-	100.0%	25.0	
4	СБГ	31	25	-	1	-	1	-	4	96.3%	24.0	
5	ХСХОГ	28	27	-	1	-	-	-	-	98.9%	24.7	
6	СТСГ	8	8	-	-	-	-	-	-	100.0%	25.0	
7	ТЗУГ	31	29	-	2	-	-	-	-	98.0%	24.5	
8	ТСГ	24	24	-	-	-	-	-	-	100.0%	25.0	
9	СХЭУГ	19	18	-	-	-	-	-	1	100.0%	25.0	
10	ХЭЗГ	10	10	-	-	-	-	-	-	100.0%	25.0	
<b>НИЙТ</b>		<b>173</b>	<b>162</b>		<b>4</b>		<b>1</b>		<b>5</b>	<b>99.3%</b>	<b>24.8</b>	

Сангийн яам 2023 оны 8 дугаар сард нийт **173** ажил төлөвлөснөөс хэрэгжилт яамны дунджаар **99.3** хувьтай байна. Сарын төлөвлөгөөний биелэлтийн үнэлгээгээр ТБТГ, ТаБГ, НБББГ, СТСГ, ТСГ, СХЭУГ, ХЭЗГ тус бүр 100 хувиар тэргүүлж байна.

СБГ-ын 1, ТЗУГ-ын 2, ХСХОГ-ын 1 ажил тус бүр 70 хувийн үнэлгээтэй, СБГ-ын 1 ажил 30 хувийн үнэлгээтэй хэрэгжилтийн шатанд байна. Төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээнд хамруулаагүй 5 ажил байгаа ба үүнд яам, газрын удирдлагын шийдвэр, бусад байгууллагын үйл ажиллагаанаас хамааралтайгаар цуцлагдсан, хойшлогдсон, асуудлыг шийдвэрлүүлэх хүсэлт ирээгүй зэрэг шалтгааны улмаас хэрэгжих боломжгүй болсон ажлууд багтаж байна. */Дэлгэрэнгүйг хавсралт 2-оос үзнэ үү/*



## Албан бичгийн шийдвэрлэлт (8 сар)

97.0  
хувь

Сангийн яаманд 2023 оны 8 дугаар сарын байдлаар нийт 2'535 албан бичиг ирснээс 2'037 бичгийн хариуг хугацаанд нь өгсөн бол хугацаа хоцроож боловсруулсан 19 албан бичиг байна. Албан бичгийн шийдвэрлэлт **97.0% хувьтай** байлаа. /Дэлгэрэнгүйг хавсралт 3-аас үзнэ үү/.

№	Газар	Боловсруулж байгаа	Боловсруулсан	Боловсруулсан /хоцорсон/	Боловсруулж байгаа /хоцорсон/	Нийт	Хувь	Оноо
1	ТБТГ	31	192	1	2	226	95.4%	9.5
2	ТаБГ	10	106	2	2	120	94.0%	9.4
3	НБББГ	5	47	-	-	52	100.0%	10.0
4	СБГ	26	189	13	1	229	95.2%	9.5
5	ХСХОГ	117	639	1	-	757	99.5%	9.9
6	СТСГ	2	3	-	-	5	91.7%	9.2
7	ТЗУГ	43	79	2	1	125	95.5%	9.6
8	ТСГ	155	533	-	-	688	99.8%	10.0
9	СХЭУГ	2	9	-	-	11	100.0%	10.0
10	ХЭЗГ	82	240	-	-	322	98.5%	9.8
<b>НИЙТ</b>		<b>473</b>	<b>2037</b>	<b>19</b>	<b>6</b>	<b>2535</b>	<b>97.0%</b>	<b>9.7</b>

Яамны 2023 оны 8 дугаар сарын 14, 21 -ны өдрүүдийн шуурхай хуралдаанаар Сангийн дэд сайд 5, ТНБД 5 нийт **10 үүрэг даалгаврыг** яамны газруудад өгсөн бөгөөд хэрэгжилтийн явц 2023 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар **100.0 хувьтай** байв. /Шуурхай үүрэг даалгаврын биелэлтийг хавсралт 4-өөс үзнэ үү/.

№	Хариуцсан газар	Шуурхай үүрэг даалгаврын тоо /давхардсан тоогоор/	Үнэлгээний дундаж	Авах оноо	Авсан оноо
1	ТБТГ	3	-	5	5.0
2	ТаБГ	1	100.0%	5	5.0
3	НБББГ	-	-	-	-
4	СБГ	2	100.0%	5	5.0
5	ХСХОГ	1	100.0%	5	5.0
6	СТСГ	1	-	5	5.0
7	ТЗУГ	2	100.0%	5	5.0
8	ТСГ	-	-	-	-
9	СХЭУГ	1	100.0%	5	5.0
10	ХЭЗГ	-	-	-	-
<b>НИЙТ</b>		<b>10</b>	<b>100.0%</b>	<b>5</b>	<b>5.0</b>



## Ажлын цаг ашиглалт (8 сар)

**94.1**  
хувь

Яамны цаг бүртгэлийн системээс авсан мэдээллээр яамны ажлын цаг ашиглалт 2023 оны 8 дугаар сарын байдлаар дунджаар **94.1 хувьтай** байна.

№	Дотоод бүтцийн нэгж	Ажлын цаг ашиглалтын хувь	Авах оноо	Авсан оноо
1	ТБТГ	94.96%	10	9.5
2	ТаБГ	96.06%	10	9.6
3	НБББГ	81.36%	10	8.1
4	СБГ	97.23%	10	9.7
5	ХСХОГ	91.75%	10	9.2
6	СТСГ	99.5%	10	10.0
7	ТЗУГ	93.03%	10	9.3
8	ТСГ	90.5%	10	9.1
9	СХЭУГ	99.6%	10	10.0
10	ХЭЗГ	97.1%	10	9.7
НИЙТ		<b>94.1%</b>	<b>10</b>	<b>9.4</b>



## Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал (8 сар)

**100.0**  
хувь

Яамны холбогдох газрууд яамны эрхэм зорилго, үйл ажиллагааны чиглэл, зохион байгуулалт, үйлчилгээ, мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм журам, заавар, сангийн яамнаас олгож байгаа тусгай зөвшөөрөлтэй холбоотой мэдээллийг яамны цахим хуудсанд байршуулж, шинэчлэн ажилласан байна. 2023 оны 8 дугаар сарын байдлаар хэрэгжилт **100 хувьтай** байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 5-аас үзнэ үү/

№	Цахим хуудсанд мэдээлэл оруулсан газрууд	Үнэлгээ	Авах оноо	Авсан оноо
1	ТБТГ	100.0%	10	10.0
2	ТаБГ	100.0%	10	10.0
3	НБББГ	100.0%	10	10.0
4	СБГ	100.0%	10	10.0
5	ХСХОГ	100.0%	10	10.0
6	СТСГ	100.0%	10.0	10.0
7	ТЗУГ	100.0%	10	10.0
8	ТСГ	100.0%	10	10.0
9	СХЭУГ	100.0%	10	10.0
10	ХЭЗГ	100.0%	10	10.0
НИЙТ		<b>100.0%</b>	<b>10</b>	<b>10.0</b>

## Дүгнэлт

1. Яамны 2023 оны 8 дугаар сард нийт төлөвлөсөн 173 ажлаас 99.3 хувийг бүрэн хэрэгжүүлж ажилласан ба харин 0.7 хувийг хэрэгжүүлж дуусаагүй (үүнд: 5 ажил) байна.
2. Газруудын албан бичиг шийдвэрлэлтийн байдал 97.0 хувьтай байна. 8 дугаар сард хариу өгөх хугацааг хоцроож шийдвэрлэсэн 19, хоцроон боловсруулж буй 6 албан бичиг байна.
3. 2023 оны 8 дугаар сарын яамны газруудын ажлын цаг ашиглалт дунджаар 94.1 хувьтай байна.



## Зөвлөмж

1. 2023 оны 8 дугаар сарын төлөвлөгөөнд гүйцэтгэхээр төлөвлөсөн боловч хэрэгжилтийн шатанд буюу удаашралтай байгаа ажлуудыг газрууд дараа сарын төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлж дуусгах;
2. Сарын биелэлтийг тайлагнахдаа хийсэн ажлын үр дүн, ач холбогдлыг бүрэн гүйцэд, товч, тодорхой бичиж, огноо, албан бичгийн дугаар зэрэг баримт мэдээллийг оруулж, шаардлагатай тайлан мэдээллийг хавсаргаж, дараа сарын 5-ны дотор тайлагнаж хэвших;
3. Албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэж буй эсэхэд газар, хэлтсийн удирдлагаас тавих, хяналтыг сайжруулах, хариу өгсөн, шийдвэрлэсэн тухай мэдээллийг албан бичгийн бүртгэлийн системд тухай бүрд нь оруулж хэвших;
4. Шуурхай үүрэг, даалгаврын биелэлтийг газрууд долоо хоног бүрийн Пүрэв гарагт хяналт-шинжилгээ, үнэлгээний ЛМ цахим системд хугацаанд нь тогтмол тайлагнаж хэвших;
5. Газар, хэлтсийн ажлын цаг ашиглалтыг сайжруулахад газар, хэлтсийн удирдлагаас тавих, хяналтыг сайжруулах.
6. Газрын сарын төлөвлөгөөг хугацаанд нь боловсруулж, батлуулахад газар, хэлтсийн удирдлагаас тавих, хяналтыг сайжруулах.

## ХАВСРАЛТ

### Хавсралт 1. Газруудын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ (8 сар)

№	Газар	Сарын төлөвлөгөө		Албан бичиг шийдвэрлэлт		Ш/Ү даалгаврын биелэлт		Ажлын цаг ашиглалт		Ү/а-ны нээлттэй ил тод байдал		НИЙТ		
		Авах оноо	Авсан оноо	Авах оноо	Авсан оноо	Авах оноо	Авсан оноо	Авах оноо	Авсан оноо	Авах оноо	Авсан оноо	Авах оноо	Авсан оноо	Эзлэх хувь
1	ТБТГ	25	25.0	10	9.5	5	5	10	9.5	10	10	60.0	59.0	98.3
2	ТаБГ	25	25.0	10	9.4	5	5	10	9.6	10	10	60.0	59.0	98.3
3	НБББГ	25	25.0	10	10.0	-	-	10	8.1	10	10	55.0	53.1	96.5
4	СБГ	25	24.0	10	9.5	5	5	10	9.7	10	10	60.0	58.2	97.0
5	ХСХОГ	25	24.7	10	9.9	5	5	10	9.2	10	10	60.0	58.8	98.0
6	СТСГ	25	25.0	10	9.2	5	5	10	10.0	10	10	60.0	59.2	98.7
7	ТЗУГ	25	24.5	10	9.6	5	5	10	9.3	10	10	60.0	58.4	97.3
8	ТСГ	25	25.0	10	10.0	-	-	10	9.1	10	10	55.0	54.1	98.4
9	СХЭУГ	25	25.0	10	10.0	5	5	10	10.0	10	10	60.0	60.0	100.0
10	ХЭЗГ	25	25.0	10	9.8	-	-	10	9.7	10	10	55.0	54.5	99.1
<b>НИЙТ</b>		<b>25</b>	<b>24.8</b>	<b>10</b>	<b>9.7</b>	<b>5</b>	<b>5</b>	<b>10</b>	<b>9.4</b>	<b>10</b>	<b>10</b>	<b>585</b>	<b>574.3</b>	<b>98.2</b>



**Хавсралт 2. Сарын төлөвлөгөөнөөс хэрэгжүүлээгүй болон хэрэгжиж дуусаагүй, удаашралтай байгаа нийт 5, үнэлгээнд хамруулаагүй 5 ажил байна. Үүнд:**

**70 хувийн хэрэгжилттэй 4 ажил:**

**Санхүүгийн бодлогын газар:**

1. Монгол Улсын Засгийн газар, КОЙКА-тай хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулагдах сургалт, арга хэмжээний хүсэлт, сайн дурын ажилтны хүсэлтийг холбогдох байгууллагуудаас хүлээн авах, хүргүүлэх (Т.Энхсаруул)  
Тайлбар: Төлөвлөгөөт хугацааг хоцроосон байна.

**Төрийн захиргааны удирдлагын газар:**

1. Яамны сар бүр гүйцэтгэсэн үйл ажиллагааны товч тайланг нэгтгэн гаргаж, цахим сүлжээгээр ЗГХЭГ-т хугацаанд нь хүргүүлж байх (Б.Болормаа)  
Тайлбар: ЗГХШҮ-ний цахим системд хугацаа хоцроосон төлөвтэй байна.
2. Яамны газруудын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал, ажлын цаг ашиглалт, албан бичгийн шийдвэрлэлт, олон нийтээр хамрагдах ажлын биелэлт гаргах (Б.Болормаа, З.Баянмөнх, Л.Сэлэнгэ, Э.Оюунсондор)  
Тайлбар: Хугацаа хоцроосон

**Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газар газар:**

1. Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журамд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл боловсруулах. (Б.Бямба-эрдэнэ, Н.Сансармаа, Б.Гэрэлмаа, Б.Амаржаргал, Г.Өлзийжаргал, Ц.Лхамсүрэн, О.Гантулга, Х.Отгонбаяр)  
Тайлбар: Тус арга хэмжээ хүрэх түвшиндээ хүрээгүй байна.

**30 хувийн хэрэгжилттэй 1 ажил:**

**Санхүүгийн бодлогын газар:**

1. "Засгийн газрын гадаад зээл авахад мөрдлөг болгох журам"-г Засгийн газраар хэлэлцүүлэн батлуулах (Н.Доржсүрэн, О.Маралмаа, У.Марал)  
Тайлбар: Төслийг дахин боловсруулж, ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна

**Сарын төлөвлөгөөнд тусгагдсан бөгөөд үнэлгээнд хамрагдаагүй 5 ажил:**

**Санхүүгийн бодлогын газар:**

1. Засгийн газрын гадаад зээллэгийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлэх журам-д Төсвийн гүйцэтгэл болон ЗГ-ын санхүүгийн нэгдсэн аудитын тайлан, санал, дүгнэлтүүдтэй уялдуулан шаардлагатай өөрчлөлтүүдийг тусгаж, газар, хэлтсийн даргад танилцуулах (А.Гүнбилиг, М.Мөнх-эрдэнэ, С.Даваацэрэн)  
Тайлбар: Хойшлогдсон байна
2. Засгийн газрын дотоод үнэт цаасыг холбогдох тушаал шийдвэрийн дагуу арилжаалах арга хэмжээг зохион байгуулах. (Д.Хашчулуу, М.Баасандорж)  
Тайлбар: Тухайн сард үнэт цаас арилжаалах тушаал, шийдвэр гараагүй байна.

3. Засгийн газрын гадаад үнэт цаасыг холбогдох тушаал шийдвэрийн дагуу арилжаалах арга хэмжээг зохион байгуулах. (О.Маралмаа, У.Марал)  
Тайлбар: Үнэт цаас арилжаалах тушаал, шийдвэр гараагүй байна.
4. Засгийн газрын өрийн баталгаа гаргах төсөл, арга хэмжээнд эрсдэлийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулах (Д.Хашчулуу, М.Баасандорж)  
Тайлбар:Тухайн сард ЗГ-ын хүсэлт, шийдвэр гараагүй

Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар:

1. Алсын хараа 2050 үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Сангийн сайдын хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг удирдлагад танилцуулан ЗГХЭГ-т хүргүүлэх (Э.Солонго)  
Тайлбар: Биелэлт авах албан бичиг ирүүлээгүй байна.

**Хавсралт 3. Хугацаа хоцорч боловсруулж дууссан болон хугацаа хоцорсон боловсруулж байгаа албан бичгийн жагсаалт (8 сар)**

**3.1.Хугацаа хоцорч боловсруулсан албан бичиг**

№	Хаанаас	Албан бичгийн дугаар	Албан бичгийн ирсэн огноо	Албан бичгийн дуусах хугацаа	Албан бичгийг хаасан хугацаа	Цохогдсон газар	Мэргэжилтэн
1	Боловсрол шинжлэх ухааны сайд Энх-Амгалан Л	1а/3518	8/3	8/17	8/18	ТБТГ	Очиртогтох Б
2	Засгийн газрын хэрэг эрхлэх газар Баасандорж Б	ХЭГ/1798	8/9	8/23	8/28	ТаБГ	Эрдэнэ Н
3	Зам тээврийн хөгжлийн сайд Бямбацогт С	01/3680	8/14	8/28	8/31	ТаБГ	Анхбаяр Т
4	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар Бямбасүрэн Л	01/3104	8/4	8/18	8/29	СБГ	Чулуун Э
5	Гадаад харилцааны сайд Батцэцэг Б	05/4069	8/8	8/22	8/28	СБГ	Түвшинбаяр Г
6	Монгол улсын засгийн газар Амарсайхан С	ЗГ-2/510	8/11	8/25	8/29	СБГ	Марал У
7	Эрүүл мэндийн сайд Чинзориг С	1а/3627	8/11	8/25	8/29	СБГ	Марал У
8	Азийн хөгжлийн банк	309/23	8/9	8/23	8/25	СБГ	Марал У
9	Америкийн нэгдсэн улсын Экспорт импорт банк	LI762436XX	8/15	8/29	8/31	СБГ	Марал У
10	Боловсрол шинжлэх ухааны сайд Энх-Амгалан Л	1а/3644	8/9	8/23	8/25	СБГ	Марал У
11	Гадаад харилцааны яам Анхбаяр Н	04/4053	8/8	8/23	8/24	СБГ	Түвшинбаяр Г
12	Засгийн газрын хэрэг эрхлэх газар Амарбаясгалан Д	ХЭГ/1808	8/15	8/29	8/31	СБГ	Түвшинбаяр Г
13	Олимп нийтийн биеийн тамир спортын үндэсний хороо Бат-Эрдэнэ Б	01/313	8/9	8/23	8/25	СБГ	Марал У
14	Олимп нийтийн биеийн тамир спортын үндэсний хороо Бат-Эрдэнэ Б	01/312	8/9	8/23	8/25	СБГ	Марал У
15	Цахим хөгжил харилцаа холбооны сайд Учрал Н	01/1577	8/9	8/23	8/25	СБГ	Марал У
16	Уул уурхай хүнд үйлдвэрийн яам Цэндсүрэн О	02/1932	8/8	8/22	8/25	СБГ	Марал У
17	Батлан хамгаалахын сайд Сайханбаяр Г	1а/2918	8/8	8/22	8/25	ХСХОГ	Хонгор Т
18	Эрүүл мэндийн яам Төгсдэлгэр С	2/3521	8/3	8/17	8/21	ТЗУГ	Золзаяа Т Энхтуяа Ц Золзаяа Т
19	Санхүүгийн зохицуулах хороо Долгорсүрэн Б	9/3055	8/4	8/18	8/21	ТЗУГ	

### 3.2 Хугацаа хоцроон боловсруулж байгаа албан бичгийн жагсаалт

№	Хаанаас	Албан бичгийн дугаар	Албан бичгийн ирсэн огноо	Дуусах хугацаа	Цохогдсон газар	Мэргэжилтэн
1	Соёлын сайд Номин Ч	1/2096	8/17	8/31	ТБТГ	Очиртогтох Б
2	Ц.Даваасүрэн, Барилга, хот байгуулалтын яам /Цахим албан бичиг/	1/2935	8/18	9/1	ТБТГ	Мөнхзул Г
3	Монгол Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг Улаанбаатар төмөр зам Хэрлэн Х	12/2714	8/3	8/17	ТаБГ	Анхбаяр Т
4	Санхүүгийн зохицуулах хороо Баярсайхан Д	1/3166	8/18	9/1	ТаБГ	Эрдэнэ Н
5	Санхүүгийн зохицуулах хороо Хүдэрчулуун Н	2/3237	8/18	9/1	СБГ	Чулуун Э
6	Цахим хөгжил харилцаа холбооны сайд Учрал Н	01/1580	8/4	8/18	ТЗУГ	Хатанбүүвэй Б

**Хавсралт 4. Шуурхай үүрэг даалгаврын тайлан (8 сар)**

Дугаар	Үүрэг, даалгавар өгсөн албан тушаалтан	Өгсөн үүрэг, даалгавар	Үүрэг, даалгавар өгсөн огноо	Хариуцах газар	Хэрэгжилтийн явц	Үнэлгээ
1	Сангийн дэд сайд	Яамнаас гадаад харилцааны чиглэлээр 2023 он дуустал зохион байгуулах арга хэмжээний төлөвлөлтийг маш сайн хийх. Хугацаатай төлөвлөж, урьдчилан танилцуулж байх.	2023.08.21	СБГ	Дэд сайдаас өгсөн үүрэг даалгаврын дагуу 2023 он дуустал зохион байгуулагдах арга хэмжээний төлөвлөгөөг танилцуулсан.	100%
2	Сангийн дэд сайд	ХЗДХ-ын сайд Х.Нямбаатарын ахалсан ажлын хэсгийн явцын талаар танилцуулах. Татварын бодлогын газар..	2023.08.21	ТаБГ	<p>Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 198 дугаар захирамжаар байгуулагдсан Монгол Улсын Их Хурлын 2021 оны “Оюу толгой ордоос Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээний тухай” 103 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, Оюу толгой төслийн гадаадын хөрөнгө оруулагч талтай яриа хэлэлцээ хийх, төслийг тохирох, эцэслэсэн хувилбарыг Засгийн газрын хуралдаанд танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсэг:</p> <p>1. УИХ-ын 103 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд авч хэрэгжүүлэх 6 арга хэмжээний нэг болох татвартай холбоотой асуудлыг шийдвэрлэх талаар Рио Тинто Зэсийн группээс ирүүлсэн саналтай холбоотой асуудлаар 2023 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн 01/5621 тоот албан бичгээр хариу саналыг Ажлын хэсгийн ахлагч, Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлсэн.</p> <p>2. Ажлын хэсгээс 2023 оны 08 дугаар сарын 1-2-ны өдийн хуралдаанаас татварын маргаантай асуудлыг шийдвэрлэх талаар хөрөнгө оруулагч талаас ирүүлсэн саналыг хэлэлцээд арбитрын маргаанд Засгийн газрын хуулийн зөвлөхөөр ажиллаж байсан Кинг энд Спалдинг хуулийн фирмийн партнер Сара Вокироос Засгийн газрын Ажлын хэсэгт тус хуулийн фирм цаашид үргэлжлүүлэн хуулийн зөвлөхөөр ажиллах боломжгүй болсон талаар захидал ирүүлсэн тул шинээр хуулийн зөвлөх сонгон шалгаруулсан</p>	100%

					бөгөөд хуульчдад хэргийн баримт материалтай танилцах хугацаа олгох шаардлагатай байгаа тул арбитрын маргаан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэн 12 сарын хугацаагаатай түдгэлзүүлэх нь зүйтэй гэж Ажлын хэсгийн дийлэнх гишүүд үзсэн болно. Үүний дагуу тус асуудлаар Хууль зүй, дотоод хэргийн сайдаас Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төслийг ирүүлсэн бөгөөд 2023 оны 08 дугаар сарын 04-ны өдрийн 01/5711 тоот албан бичгээр саналаа хүргүүлсэн болно. 2023 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулж арбитрын маргаан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлсэн хугацааг үргэлжлүүлэн 6-12 сараар сунгах тухай Засгийн газрын хуралдааны 31 дүгээр тэмдэглэл гарсан. Яамны удирдлагуудад 08 дугаар сарын 22-ний өдөр танилцуулсан.	
3	Сангийн дэд сайд	Монгол Улсын Засгийн газраас гаргасан салбарын үйл ажиллагаатай холбоотой тогтоол, шийдвэрийн биелэлтийн гүйцэтгэл ямар байна, орхигдсон, хоцорсон ажил байгаа эсэхийг тодруулж, танилцуулах. Цаашид биелэлт дээр анхаарах.	2023.08.21	СХЭУГ	Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын тогтоол, хуралдааны тэмдэглэл, албан даалгаварт тусгагдсан, Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах арга хэмжээний хэрэгжилтэд СХЭУГ-аас холбогдох журмын дагуу хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, тайланг ЗГ-ын ХШҮ-ний цахим системд сар бүр, тогтоосон хугацаанд нь бүрэн илгээн ажиллаж байна. 2023 оны 7 дугаар сарын эцсийн байдлаар дээрх тогтоол шийдвэрийн нийт 229 заалтыг Сангийн яам болон түүний харьяа байгууллагууд хяналтад авч ажилласан бөгөөд хэрэгжилтийн явц 90.65 хувьтай байлаа. Нийт арга хэмжээнээс хэрэгжилт хангалтгүй 11 арга хэмжээ, хэрэгжилтийн шатанд байгаа 32 арга хэмжээ байсан ба холбогдох танилцуулгыг бэлтгэн, хавсралтын хамтаар яамны удирдлагуудад 2023 оны 8 дугаар сарын 22-ны өдөр танилцуулсан.	100%
4	Сангийн дэд сайд	Салбарын хэмжээнд хэрэгжүүлж байгаа бүтээн байгуулалтын ажлууд дээр анхаарч, шахаж ажиллах.	2023.08.21	ХСХОГ	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төслүүдэд PIMIS цахим системийг ашиглан захиалагчийн хяналт, захиалагч байгууллагууд болон тус яамнаас гүйцэтгэлийн хяналтыг өдөр тутам хянаж байна. Мөн онцгой анхаарах төслүүд дээр захиалагч байгууллагатай холбогдон	100%

					шаардлагатай мэдээллийг өдөр тутамдаа авч ажиллаж байна	
5	Сангийн дэд сайд	Монгол Улсын 2024 оны төсвийн төслийг боловсруулахад анхаарч ажиллах.	2023.08.21	ТБТГ	Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсруулахад шаардлагатай судалгаа, тооцоолол, танилцуулгыг бэлтгэж, Төсвийн ерөнхийлөн захирагчдаас ирүүлсэн төсвийн саналыг хянаж байна.	100%
6	ТНБД	Яамны албан хаагчдын ээлжийн амралтын асуудлыг анхаарах. Амралтаа тасалж авч байгаа албан хаагчид заавал мэдэгдэж байж амрах	2023.08.14	ТЗУГ	Газар хэлтсийн дарга нарт ээлжийн амралтын талаар мэдээлж, албан хаагчид амралтын хуваарьт өөрчлөлт орсон талаар тухай бүр хүний нөөцийн программд оруулж баталгаажуулсан болно. 8 дугаар сарын 14-17-ны өдрүүдэд нийт 8 албан хаагч амралтын мэдэгдлээ авсан болно	100%
7	ТНБД	Энэ 7 хоногт яаман дээр Буриад Улсын Сангийн сайд айлчилна. Өндөр ач холбогдол өгч, холбогдох уулзалт арга хэмжээг сайн зохион байгуулах.	2023.08.14	СБГ	Буриад Улсын Сангийн сайд болон албаны бусад төлөөлөгчдийг 8 дугаар сарын 16-ны өдөр хүлээн авч, холбогдох уулзалтыг зохион байгуулсан.	100%
8	ТНБД	Монгол Улсын 2024 оны төсөв дээр анхаарах. Харьяа байгууллагууд бас анхаарах, ирэх оны төсвийг хийсэн ажлынхаа үр дүнг танилцуулах, цахим, ил тод нээлттэй болсон талаар гол гол хийгдсэн ажлуудыг оруулан дүгнэсэн, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар анхаарсан төсөв хийх.	2023.08.14	ТБТГ	Төсвийн тухай хуульд заасан цаглабарын дагуу 21 аймгийн 2024 оны төсвийн төсөөллийн саналыг хүлээн авч суурь орлого болон суурь зарлагыг хянасан. Төсвийг цахим, ил тод, нээлттэй болгох ажлын хүрээнд иргэд жилийн турш саналаа өгч болох цахим талбарыг Иргэдийн төсвийн цахим систем / <a href="http://www.iltod.mof.gov.mn">www.iltod.mof.gov.mn</a> /-д байршуулсан. Тодруулбал тус цахим хуудасны "Иргэдийн оролцоо" цэсийн "Санал асуулга" модулийн тусламжтайгаар иргэд олон нийтээс санал авах боломжтой болсон. Мөн "Хэлэлцүүлэг" модулийн тусламжтайгаар төсвийн тухай хууль, журам болон төсөвтэй холбоотой аливаа асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлэх цахим талбарыг нэмэлтээр хөгжүүлэн ашиглалтад оруулсан бөгөөд Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсруулах явцад ашиглах боломжтой.	100%
9	ТНБД	Хөгжлийн хөтөч төсөл Гашуун сухайт боомтын асуудалд дээр онцгой анхаарах. Экспорт гацах вий, эрсдэлээ сайн тооцоолох. Зураглал дээр анхаарах. Боомтуудын ажлын гүйцэтгэлийн явцад анхаарах,	2023.08.21	ТЗУГ	Хилийн боомтуудын ажлын гүйцэтгэлийн талаар яамны удирдлагад холбогдох танилцуулгыг хийсэн. Бичигт хилийн боомтын өргөтгөл шинэчлэлтийн бүтээн байгуулалтын ажлын цахилгаан хангамжийн хүчинтэй хугацааг сунгуулах, зураг төсөлд өөрчлөлт оруулах	100%

		яамнаас шалтгаалах асуудал байгаа эсэхийг сайн тодруулах.			хүсэлтийг ЭХЯ-нд хүргүүлж, холбогдох газрын удирдлагуудтай уулзалт зохион байгуулсан.	
10	ТНБД	Монгол Улсын 2024 оны төслийн төслийг боловсруулах ажлыг шуурхайлах. ЭЗХЯ- тай энэ 7 хоногт уулзаж макро тоонуудаа тохирох. Яамны удирдлагын түвшинд уулзалт зохион байгуулах.	2023.08.21	СТСГ, ТБТГ	ЭЗХЯ-тай 2024 оны Төсвийн төсөл боловсруулахтай холбоотойгоор Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн төсөөлөл, шаардлагатай тоонуудыг тохирох уулзалтыг амжилттай зохион байгуулсан.	100%
<b>ДУНДАЖ</b>					<b>100.0 %</b>	



**Хавсралт 5. Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал (8 сар)**

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хариуцсан газар
Нэг. Үйл ажиллагааны ил тод байдал			
1.	<p>Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;</p>	<p>Яамны эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнг яамны цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр тухай бүр олон нийтэд мэдээлэн ажилласан.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2024 оны төсвийн төсөл бэлтгэх удирдамж;</li> <li>- Иргэдийн төсөв, Шилэн дансны цахим хуудасны хэрэглэгчийн судалгаа</li> <li>- Нээлттэй төсөв эрдэм шинжилгээний 2023</li> <li>- Яамны нэгжүүдийн 2023 оны 7 дугаар сарын хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан</li> <li>- Экспортод гаргасан ашигт малтмалын бүтээгдэхүүний 2023 оны 8 дугаар сарын зах зээлийн үнийн мэдээлэл зэргийг 2023 оны 8 дугаар сард яамны цахим хуудсанд байршуулсан. <a href="https://mof.gov.mn/article/budget/zah-zeel-uniin-medeelel">https://mof.gov.mn/article/budget/zah-zeel-uniin-medeelel</a></li> <li>- Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны эхний хагас жилийн гүйцэтгэл. <a href="https://mof.gov.mn/data_grid/total-budget">https://mof.gov.mn/data_grid/total-budget</a></li> <li>- Төсвийн чиглэлээр олон нийтэд хүргэх мэдээллийг өргөжүүлэх, ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилгоор 2023 оны эхний хагас жилийн эдийн засаг, төсвийн тоймыг боловсруулж, Сангийн яамны цахим хуудас болон ил тод байдлын цахим хуудас (<a href="http://www.iltod.mof.gov.mn">www.iltod.mof.gov.mn</a>)-нд байршуулсан</li> <li>- Монгол Улсын төлбөрийн тэнцлийн 2023 оны эхний хагас жилийн байдлын талаарх мэдээллийг 2023 оны 8 дугаар сарын 28-ны өдөр яамны фейсбүүк пэйж хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж ажилласан. Монгол улсын төлбөрийн тэнцэл 2023 оны эхний хагас жилийн байдлаар 473.8 сая ам.долларын ашигтай гарлаа. Энэ нь 2019 оноос хойш анх удаа ашигтай гарч буй үзүүлэлт юм. 2022 оны эхний хагас жилийн байдлаар төлбөрийн тэнцэл 1.1 тэрбум төгрөгийн алдагдалтай гарч байжээ. <a href="https://www.facebook.com/photo/?fbid=600728628917241&amp;set=a.177530921237016">https://www.facebook.com/photo/?fbid=600728628917241&amp;set=a.177530921237016</a></li> <li>- Олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч “Фитч” /Fitch Ratings/ агентлагаас “МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН СОРИЛТ БА ТОГТВОРТОЙ ИРЭЭДҮЙГ ЦОГЦЛООХ НЬ” сэдэвт хурал зохион байгуулсан. Хуралд оролцсон талаарх мэдээллийг яамны цахим хуудсанд 2023 оны 8 дугаар сарын 17-ны өдөр байршуулсан. <a href="https://www.facebook.com/photo?fbid=595343266122444&amp;set=pcb.595343302789107">https://www.facebook.com/photo?fbid=595343266122444&amp;set=pcb.595343302789107</a></li> <li>-</li> </ul>	ТЗУГ, бүх газрууд
2.	<p>Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн</p>	<p>Яамны өргөдөл, гомдол хариуцсан ажилтны холбогдох мэдээлэл, утсыг /267246, 110/ яамны цахим хуудас болон 1 давхрын цахим самбарт байршуулсан. “Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах төв”-өөс ирүүлсэн санал хүсэлтэд тухай бүр шуурхай хариуг өгч, тайланг ЗГХЭГ-т хүргүүлэн ажиллаж байна. 2023 оны 8 дугаар сарын байдлаар Засгийн газрын 11-11 төвөөр дамжин ирүүлсэн нийт 87 санал хүсэлт, өргөдөл гомдлыг бүртгэн авч, шуурхай шийдвэрлэн 100 хувийн биелэлттэй хариуг өгч ажилласан болно.</p>	ТЗУГ

	самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;		
3.	Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Сангийн яамны цахим хуудас болон фейсбүүк пэйж хуудсаар 2023 оны 7 дугаар сарын 17-ны өдөр ААНБ-уудад хандан гадаад иргэнд захирлын эрх олгох шалгуурын талаар мэдээлсэн болно. <a href="https://www.facebook.com/MOFMongolia">https://www.facebook.com/MOFMongolia</a> . Баяр наадмын өдрүүд тохиосонтой холбоотой аж ахуйн нэгж, байгууллагын 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг хүлээн авах хугацааг 2023 оны 07 дугаар сарын 27-ны өрийг хүртэл сунгасан талаарх мэдээллийг яамны цахим хуудас болон фейсбүүк пэйж хуудсанд 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдөр байршуулж, олон нийтэд мэдээлсэн болно. <a href="https://www.facebook.com/MOFMongolia">https://www.facebook.com/MOFMongolia</a>	НБББГ
4.	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Сангийн яаманд ирүүлсэн тендерийн гомдол, шийдвэрлэлтийн талаарх мэдээг 2023 оны 08 дугаар сарын байдлаар гарган, яамны цахим хуудасны ил тод хэсэгт байршуулсан. ( <a href="https://mof.gov.mn/article/entry/2023_08">https://mof.gov.mn/article/entry/2023_08</a> ) - Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд худалдан авах ажиллагааны хар жагсаалтад орсон байгууллагын мэдээллийг сар бүр оруулдаг болно. <a href="https://www.tender.gov.mn/mn/bidder/blacklist">https://www.tender.gov.mn/mn/bidder/blacklist</a> - Яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газраас яамны цахим хуудсанд сар бүрийн үнийн мэдээллийг тогтмол байршуулж байна. <a href="https://mof.gov.mn/article/budget/zah-zeel-uniin-medeelel">https://mof.gov.mn/article/budget/zah-zeel-uniin-medeelel</a>	Бүх газрууд
5.	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төслийг цахим хуудсандаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах;	- Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу яамны гүйцэтгэх албан тушаалын, Татварын ерөнхий газрын дотоод бүтцийн нэгжийн удирдах албан тушаалын сул орон тоог нөхөх тухай зарыг 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдөр Сангийн яамны төрийн албаны салбар зөвлөлөөс яамны цахим хуудсанд байршуулж, зохион байгуулсан. <a href="https://hh.csc.gov.mn/?sector_id=02001005&amp;offset=1&amp;limit=10">https://hh.csc.gov.mn/?sector_id=02001005&amp;offset=1&amp;limit=10</a> . - Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар эцэслэн баталсан тул тус хуулийн дагуу боловсруулж, батлах захиргааны хэм хэмжээний актын дараах төсөлд санал авах мэдээллийн яамны цахим хуудсанд 2023 оны 07 дугаар сарын 07-н өдөр байршуулсан болно. <a href="https://mof.gov.mn/article/entry/2023071701">https://mof.gov.mn/article/entry/2023071701</a>	ТЗУГ
6.	Үзүүлж байгаа үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;	- Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны шинэчилсэн хувилбарыг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нэвтрүүлж, тус системд нийт 6,084 байгууллага, 10,832 хэрэглэгчийг бүртгэсэн ба хуулийн хэрэгжилт, системийн хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна. Байгууллага бүртгүүлэх, байгууллагын тайлан оруулах явцад утсаар болон цахимаар заавар зөвлөгөө тогтмол өгч, нэмэлт сайжруулалтын саналыг системийн хөгжүүлэгчдэд хүргүүлж, тулгамдсан асуудлыг шийдвэрлэн ажиллалаа. Хэрэглэгчдээс ирүүлсэн улирлын тайлан илгээхтэй холбоотой саналыг хүлээн авч шийдвэрлэсэн.	ХСХОГ
7.	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа	Байхгүй	

	<p>тохиолдолд тухайн төрийн бус байгууллагын нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх;</p>		
8.	<p>Тухайн байгууллага тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог бол тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;</p>	<p>Сангийн яамны цахим хуудас /mof.gov.mn/-ны Ил тод хэсэгт Сангийн яамнаас олгодог дараах зөвшөөрлийн холбогдох мэдээллийг тогтмол мэдээлдэг болно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Эд мөнгөний хонжворт сугалаа эрхлэх тусгай зөвшөөрөл;</li> <li>• Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл;</li> <li>• Аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл;</li> <li>• Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл</li> <li>• Хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл;</li> <li>• Үнэт цаас үйлдвэрлэх тусгай тусгай зөвшөөрөл.</li> </ul>	Бүх газрууд
9.	<p>Салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлын талаарх мэдээллийг цахим хуудсандаа байрлуулан тухай бүр шинэчлэх;</p>	<p>Салбарын хэмжээнд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, өр төлбөр, зээл тусламжтай холбоотой мэдээллийг тухай бүр яамны цахим хуудсанд байршуулан олон нийтэд мэдээлсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Бүгд найрамдах Энэтхэг улсаас Монгол улсад суугаа элчин сайд М.П.Сингх болон БНЭУ-ын “Эксим” банкны төлөөлөгчдийг хүлээн авч уулзан, “Газрын тос боловсруулах үйлдвэрийн төсөл”-ийн хүрээнд хийгдэх 3 багц ажлын зээлийн дэд гэрээг үзэглэлээ. Дэд зээлийн гэрээг байгуулснаар Монгол улсын Засгийн газар 2016 онд Бүгд Найрамдах Энэтхэг Улсын “Эксим” банкттай байгуулсан 1.0 тэрбум ам.долларын зээлийн эргэн төлөлтийн хуваарьт өөрчлөлт оруулах, ЕРС-02 болон ЕРС-03 багц ажлын гэрээний үндсэн төлбөрөөс чөлөөлөх хугацааг дахин 7 жилээр сунгах, Богино хугацаанд их хэмжээний төлбөр төлөх байсан төсвийн дарамтын бууруулах, ЕРС-02 болон ЕРС-03 багц ажлын гүйцэтгэгчийн гэрээг баталгаажуулж, гүйцэтгэгч компаниудын санхүүжилтийг олгож эхэлснээр Монгол улс БНЭУ-ын Засгийн газар хоорондын хамтын ажиллагаанд стратегийн өндөр ач холбогдол бүхий “Газрын тос боловсруулах үйлдвэрийн төсөл” саадгүй үргэлжлэх зэрэг давуу талууд бий болж байна. <a href="https://www.facebook.com/photo?fbid=595322416124529&amp;set=pcb.595322809457823">https://www.facebook.com/photo?fbid=595322416124529&amp;set=pcb.595322809457823</a></li> <li>- Сангийн сайд Б.Жавхлан Европын сэргээн босголт хөгжлийн банкны Төв Азийн бүсийн захирал Сюзанна Харгитай, Европын сэргээн босголт хөгжлийн банкны Монгол дахь суурин төлөөлөгч Ханнес Такач нарыг хүлээн авч уулзлаа. Уулзалтын үеэр Монгол Улсын Засгийн газартай 2019 онд байгуулсан 300.0 сая ам.долларын Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд дэд бүтэц, авто зам, болон эрчим хүчний салбаруудад хэрэгжиж буй төслүүд болон шинээр байгуулах Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийн талаар талууд санал солилцлоо. <a href="https://www.facebook.com/photo/?fbid=579803064343131&amp;set=pcb.579803441009760">https://www.facebook.com/photo/?fbid=579803064343131&amp;set=pcb.579803441009760</a></li> </ul>	ХСХОГ СБГ
Хэсгийн дундаж хувь:			100%